

БАТЛАВ.  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГА



Б.БААСАНДОРЖ

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

ШАТАХУУН НИЙЛҮҮЛЭХ  
ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ

Төслийн нэр: УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ШАТАХУУН  
НИЙЛҮҮЛЭХ

Харьцуулалт/  
гэрээнд дугаар: УБЕГ/201901005

Улаанбаатар хот

## НЭГ: ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо : 2019-02-18

Тендер шалгаруулалтын нэр: **Улсын бүртгэлийн ерөнхий газрын шатахуун нийлүүлэх**

Тендер шалгаруулалтын дугаар: УБЕГ/201901005

**Улсын бүртгэлийн ерөнхий газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос шатахуун нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.**

Энэхүү барааны тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.


Тендерт оролцог нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50000 /тавин мянга/** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстай.

Үнийн саналыг **2019.02.27-ны өдрийн 10 цагаас** өмнө цахим системд ирүүлэх буюу нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2019.02.27-ны өдрийн 10 цаг 50 минутад** Улсын бүртгэлийн ерөнхий газрын төв байр 1 давхар 103 тоот өрөөнд нээнэ.

Дотоодын давуу эрх тооцох эсэх: Тооцно

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Сүхбаатар дүүрэг 7 дугаар хороо Их тойруу, Деневерийн гудамж  
**Улсын бүртгэлийн ерөнхий газрын төв байр 2 давхар 209 тоот**  
Ц.Ганчимэг Утас :320907,




**Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА**

- |                                                         |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |
|---------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</b> | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.                                                                                                                                                                                                                               |
| <b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b>               | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.<br>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.                                                                                                                                                                                                                                                                                            |
| <b>3. Тендерийн иж бүрдэл</b>                           | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:<br>(а) Үнийн санал;<br>(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;<br>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;<br>(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;<br>(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]                                                                                              |
| <b>4. Тогтмол үнэ</b>                                   | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.                                                                                                                                                                                                                                                                                            |
| <b>5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд</b> | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.                                                                                                                                                                                                                                                                    |
| <b>6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</b>           | 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |
| <b>7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх</b>            | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш <b>45</b> хоногийн хугацаанд хүчинтэй байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |
| <b>8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл</b>      | 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.<br>7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарыт заасан бараа нь <b>ТШӨХ-д</b> заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.<br>7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |
|                                                         | 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.                                                                                                           |



**Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-НЫХОЛБОГДОХЗААЛТ	Шалгуур үзүүлэлт
<b>ТӨӨЗ 1.1</b>	<p>а. Үнийн санал;</p> <p>б. Сүүлийн 2 жилийн <b>/2017 он, 2018 он/ туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/;</b></p> <p>в. Сүүлийн 2 жилийн <b>/2017 он, 2018 он/ санхүүгийн баталгаажуулсан тайлан;</b></p> <p>г. Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар <b>бүрэн төлсөн байна.</b></p> <p>Татварын ерөнхий газрын <a href="http://www.e-tax.mta.mn">www.e-tax.mta.mn</a> сайтаас худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn">/www.tender.gov.mn/</a>-ээр дамжуулан татварын өртэй эсэх талаарх мэдээллийг лавлана. Мөн холбогдох мэдээллийг лавлахад татгалзах зүйлгүй тухай тендерт оролцгчийн <b>албан мэдэгдэл ирүүлнэ..</b></p> <p>д. Тендерт оролцогч тухайн ажилд шардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>-Гарал үсслийн гэрчилгээ</li> <li>-Шатахуун импортлох тусгай зөвшөөрлийн хуулбар;</li> <li>-Стандарт хэмжил зүйн газраас хүлээн зөвшөөрсөн лабораторт хийгдсэн барааны чанар байдлын дүгнэлт /сүүлийн 3 сарын дотор хийгдсэн байх/;</li> </ul> <p>е. Бараа нийлуулэх хуваарь</p> <p>ё. Бусад нэмэлт шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> <li>-Шатахуун нийлуулэх нэмэлт үйлчилгээ /шатахуун түгээгүүрийн газрын байршил, цахим сүлжээний мэдээлэл, үйлчилгээний үнэ тарииф/;</li> <li>-Шинэ үйлчилгээ, хөнгөлөлт, урамшуулалын нөхцлүүд;</li> <li>-Нийлуулэлтийн хугацаанд лаборториар шинжлүүлж, стандарт хангаж байгааг тодорхойлохыг татгалзах зүйлгүй талаарх мэдэгдэл ирүүлнэ.</li> </ul> <p align="center"><b>ТШӨХ-д заасан материалуудын аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно.</b></p>
<b>ТӨӨЗ 2.1</b>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: <b>2019 оны 02 дугаар сарын 27-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>10 цаг 00 минут</b></p> <p>Уг тендер нь цахим тендер шалгарулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn/">/www.tender.gov.mn/</a>-д өөрийн аж ахуйн нэгжийн тоон гарын үсгээр нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ.</p> <p>Цахим тендерийн урилгад заасан тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим системийн серверийн цагаар тооцогдох бөгөөд хугацаа хоцорсон тендерийг хүлээн авахгүй.</p>
<b>ТӨӨЗ 2.1</b>	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Сүхбаатар дүүрэг 7-р хороо Их тойруу, Деневерийн гудамж Улсын бүртгэлийн ерөнхий газрын Төв байр Даехар болон өрөөний дугаар: [1-р даехар хурлын заал, 103 тоот]</p> <p>Огноо: <b>2019 оны 02 дугаар сарын 27-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>[10 цаг 50 минут]</b></p>
<b>ТӨӨЗ 6.2</b>	Энэхүү тендер шалгарулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>багцгүй</b>



## Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**1. Барааны тодорхойлолт:** Бензин АИ-92 Монгол улсын болон Олон улсын стандартын шаардлага хангасан гэрчилгээтэй байх. Шатахуун түгээгүүрийн сүлжээ, газрууд болон картын төвтэй захиалагчийг холбосон нэгдсэн сүлжээтэй байх. Шатахууны октаны тоо нь шаардлагатай хэмжээнд байх.

**2.Стандарт:** Тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.

**3. Бараа авах хэлбэр:** Шатахууны талон авна

**4.Бараа хүргэх газар:** ШТС-аар дамжуулан шатахуун олгох зөвшөөрлийн дагуу жолоочид олгоно.

**5. Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

### БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Шатахууны нэр	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
				Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгч ийн санал болгосон хугацаа
1	3	4	5	6	7	8
Бензин АИ-92	14563	Литр	УБЕГ	Гэрээ байгуулснаас хойш ажлын 1 хоногт	2019.12.26	
Нийт	14563	Литр				



## Дөрөв. ЖИШИГ МАЯГТ

### 1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойло лт	Бараан ы гарал үүслийн улс	Тоо ширхэ г	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:



## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамарагч.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				



## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

<b>1. Шалгах болон турших</b>	1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
<b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт</b>	2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
<b>3. Оюуны өмчийн эрх</b>	3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
<b>4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх</b>	4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
<b>5. Баталгаат засварын хугацаа</b>	5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>[тоо]</b> жил байна.
<b>6. Гэрээнд өөрчлөлт оруулах</b>	6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
<b>7. Төлбөр</b>	7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>[ГТН-д заасан тоо]</b> хоногийн дотор шуурхай хийнэ.
<b>8. Бараа нийлүүлэх хуваарь</b>	8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
<b>9. Алданги оногдуулах</b>	9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
<b>10. Үүргээ биелүүлээгүй-тээс гэрээг цуцлах</b>	10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
<b>11. Маргааныг шийдвэрлэх</b>	11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.



## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |                                                                     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |
|---------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</b>                             | 1.1. Нийлүүлэлтийн хугацаанд лаборториар шигжлүүлж, стандарт хангаж байгааг тодорхойлно.                                                                                                                                                                                                                                                                                                        |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</b> | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:<br><br>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;<br>2) барааны гарал үүслийн гэрчилгээ.<br><br>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна. |
| <b>7.Төлбөр (ГЕН – 7)</b>                                           | 7.1 Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:<br><br>Захиалагч бараа хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн, тухайн нийлүүлэгчтэй харилцан тохиролцсоноор нэхэмжлэхийн дагуу төлбөрийг улиралд 1 удаа төлнө.                                                                                      |
| <b>9.Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>1</sup></b>                   | 9.1. Алданги оногдуулах хувь: <i>Хугацаа хэтэрсэн хоног тутамд нийлүүлээгүй бараа, бүтээгдэхүүний үнийн дүнгийн 0.1 хуев.</i><br><br>Алдангийн нийт дүн: <i>Нийлүүлээгүй бараа, бүтээгдэхүүний үнийн дүнгийн 10%</i>                                                                                                                                                                            |
| <b>11.Маргааныг шийдвэрлэх</b>                                      | 11. Монгол улсын холбогдох хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.                                                                                                                                                                                                                                                                                                                                 |

<sup>1</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиастустусхэтрэхгүй.



## Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ<sup>2</sup>

### БАТЛАВ.

#### ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)  
(Гарын үсэг)  
(Албан тушаал)

#### НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)  
(Гарын үсэг)  
(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]


..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нэгөө талаас [нийлүүлэгчийн нэр] (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож оны \_\_ сарын \_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

- Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
- Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “бараа” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
- Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
- Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_ -наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
- Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>3</sup>;  
Үнийн санал;

<sup>2</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.  
<sup>3</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.



Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг]\_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг]\_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**

